



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 33

Мандалговь

Үндсэн хөрөнгө төрийн өмчид
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан нийт 229,757,378 /хоёр зуун хорин есөн сая долоон зуун тавин долоон мянга гурван зуун далан найм/ төгрөгийн үнэ бүхий Сайнцагаан сумын Далай хорооллын 0,4 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээг ашиглагч байгууллага болох “Багануур Зүүн Өмнөд Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ТӨХК-ийн “Дундговь Цахилгаан Түгээх Сүлжээ Салбар”-ын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Адъяасүрэн)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Сайнцагаан сумын Далай хорооллын 0,4 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээний байгууламжийг төрийн өмчид шилжүүлэх ажлыг зохих хууль тогтоомж, журмын дагуу шийдвэрлүүлэх.


3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.



ДАРГА

С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 06 дугаар сарын 27-ны бөдрийн
33 дугаар тогтоолын хавсралт



Төрийн өмчид бүртгэх хөрөнгийн мэдээлэл

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн /төгрөг/	Ашиглалтад оруулсан комиссын акт		Бүртгэх байгууллага
				Огноо	Дугаар	
1	Сайнцагаан сумын Далай хорооллын 0,4 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам	188ш 0.4кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын төмөр бетон тулгуур шон	229,757,378	2021-12-19	21/2021	"Багануур Зүүн Өмнөд Бүсийн Цахилгаан Түгээх Сүлжээ" ТӨХК-ийн "Дундговь Цахилгаан Түгээх Сүлжээ Салбар"
Нийт			229,757,378	/хоёр зуун хорин есөн сая долоон зуун тавин долоон мянга гурван зуун далан найм/ төгрөг		